

Гадуурхал сургуульд байх ёсгүй

БУЮУ ГАДААД ИРГЭДИЙН ХҮҮХДҮҮДИЙН
БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХИЙН ТУХАЙ ЭЦЭГ
ЭХ БАГШИД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



Агуулга

1. БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ЗААВАЛ ХАМРАГДАХ БОЛОВСРОЛ 6
 2. СУРГУУЛЬД СУРАГЧИЙГ БҮРТГЭХ ҮЕД ЮУ ШААРДАЖ БОЛОХ 8
 3. ХЭД ДҮГЭЭР АНГИД ХУВИАРЛАХ - ХЭЛНИЙ ЧАДВАРЫН ТҮВШИН ЭСВЭЛ НАС ШИЙДДЭГ ҮҮ? 10
 4. ХЭЛИЙГ ЭЗЭШИХ НЬ ЧУХАЛ 12
 5. ЭЦЭГ ЭХ Ч ӨӨРСДИЙН ҮҮРЭГТЭЙ 14
 6. АНГИ ДАВТАН СУРАХ НЬ ШИЙДЭЛТ БИШ 16
 7. БАГА СУРГУУЛИАР ЗОГСОХ ЁСГҮЙ 18
 8. АНГИ ДАХЬ ХАРИЙГ ЖИГШИХ ҮЗЭЛ 20
 9. АЛБАН БУС БОЛОВСРОЛ НЬ ЯЛГААГҮЙ/АДИЛ ЧУХАЛ 22
 10. БҮХ ЗҮЙЛ ЦЭЦЭРЛЭГТ ЭХЭЛНЭ 24
 11. ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН БЭРШХЭЭЛТЭЙ ТОХИОЛДОЛД
(СУРГУУЛИЙН ЗӨВӨЛГӨӨ ӨГӨХ ТӨВИЙН ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ) 26
- ХОЛБОО БАРИХ 28

META – залуу гадаад иргэдэд зориулсан ТББ-аас гарын авлагыг хэвлэн гаргав 2016 он

График засварыг: Ondřej Polony

ISBN 978-80-88171-02-7


ISBN 978-80-906296-6-0 META: Diskriminace do školy nepatří!, Praha 2016, 1. vydání

ISBN 978-80-906296-9-1 (vietn.vyd.online)

ISBN 978-80-88171-03-4 (angl.vyd. online)

ISBN 978-80-88171-04-1 (rus.vyd. online)

ISBN 978-80-88171-01-0 (arab.vyd. online)



Эрхэм уншигчдаа

Бид эхэндээ ялгаварлан гадуурхах гэдэг нэр томьёог тойрохоор хичээсэн ч эцэст нь хэрэглэхээр болсон. Хүүхдүүд эцэг эх, сургууль болон өөр хэн нэгнээс шалтгаалан үе тэнгийнхэнтэй зэрэгцэн сургуульд сурч, өөрийгөө хөгжүүлж чадахгүй байх нь байж болох зүйл гэж үү? Сурч боловсрох нь Хүүхдийн эрхийн тухай конвенцээр тунхагласан хүний үндсэн эрх юм. Үүнийг бид бүгд ухаарах ёстой. МЕТА-ийн энэхүү материалын зорилго нь эцэг эх, сурагчид, сургуулийн захирал, ТББ-ын ажиллагсад, улсын болоод төрийн байгууллагын ажилчид гээд бид бүгдээрээ баримтлах мөн ялгаварлан гадуурхах байдлыг хэрхэн шийдвэрлэх, түүнийг тойрон гарах зорилготой билээ. Дараах хуудсуудаас бидний ажлын явцад байнга тулгардаг асуудлуудыг олж уншихаас гадна хүүхэд сургуульд элсэн орсон эсвэл цаашид түүнтэй үргэлжлүүлэн ажиллаж байгаа эсэхэд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байдлыг олж мэдэх болно. Үүнд хамгийн нэгдүгээрт тулгардаг асуудал гэвэл сургуульд элсэн орж байгаа гадаад иргэдийн хүүхдийн чех хэл мэдэхгүй байдалыг үл ойлгох, дараагийнх нь чех хэлийг хоёрдагч хэл болгон заах боловсролын системийн дутагдалтай байдлын тухай юм. Бидний гол чиглэл зорилго нь энэхүү гарын авлагаар эцэг эх, багш нарт хамтын нэгдсэн арга барилыг олох, хэрэгцээт мэдээллийг хүргэх, тулгарч буй асуудлыг зөв зохистой шийдвэрлэх боломжуудыг санал болгоход оршино. Гарын авлагын бүлэг бүр эцэг эх, багш нарт тусд нь зориулсан зөвлөмж, мэдээлэл агуулах бөгөөд эдгээр нь аль аль талдаа ашигтай байж болох юм. Энд сургуульд заавал хамрагдах хугацааг хамардаг бага сургуулийн нөхцөлд шийдвэрлэх тал дээр илүү анхаарсан байгаа. Нөгөө талаас, сургуулийн ямар түвшинд байх нь чухал биш бөгөөд гол нь асуудлын шийдэл нь ижил төстэй байж болно.

Бүлэг бүрт ашиглаж буй үндсэн материал нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, БН Чех улсын хүүхэд залуучуудын зөвлөл, БСШУЯ-ны Хүүхдийн Эрхийн тухай компани ажлын материал зэргээс ашигласан болно¹. Мэдээж бид боловсролын тухай хуулийг мартаагүй? МЕТА нь www.inkluzivniskola.cz вэб портал сайтыг тасралтгүй амжилттайгаар ажиллуулж байгаа бөгөөд тус сайтаас Чех улсын их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудад гадаадын оюутан сурагчидтай ажиллах сэдэв, зөвлөмж, хичээл болон хэрэгцээт материалын холбоосуудыг ашиглаж болно.

Дараагийн бүлгүүдэд вэб портал сайтыг ашиглахыг зөвлөх ба түүнийг зөвхөн багш нарт гэлтгүй эцэг эхчүүдийг мөн ашиглан уншихыг зөвлөх болно. Амьдрал дээр бүх хүсэлт хүлээлтүүд, бүх боломжуудыг ашиглаж хүлээсэн үүргээ биелүүлэх нь хэцүү гэдгийг мэдэх ч олон дахин оролдох нь чухал юм. Энэхүү гарын авлага нь танд тус болно гэдэгт бүрэн итгэлтэй байна.

МЕТА төрийн бус байгууллага Tereza Günterová

Жич: Дурдагдаж буй нэр болон хувийн мэдээллүүдийг өөрчилсөн болно

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гишүүн бүх орон баталсан. Үүнээс хойш онцгой байдлаар АНУ-аас бусад дэлхийн бусад бүх орон даган мөрдөж байгаа хүний эрхийг зарласан хамгийн өргөн тархсан конвенц болсон. БН Чех Улс 1991 онд 3/1993 тоот хуулийн хүрээнд конвенцийг хэрэгжүүлж байна. Мөн хууль тогтоох түүнд тайлбар, хэрэгжүүлэхдээ конвенцийг баримтлах түүнийг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн.

2016 оны 9 дүгээр сараас **боловсролын тухай хуулийн шинэчлэн өөрчлөлтийг** хүлээж буй болно. Одоогоор түүний батлагдаагүй хувилбарыг энэ хэвлэлтэнд ашиглаж болохгүй ч тодорхой хүлээгдэж буй үндсэн өөрчлөлтийг доор дурдаж буй болно.

Хичээл явагдаж буй хэлийг ойлгохгүй байгаа буюу тусгай зөвлөгөө өгөх төв (сэтгэл зүй, тусгай боловсролын зөвлөгөө өгөх төв) - өөс санал болгосон хүүхдүүд, сурагчдыг дэмжих боломжийг сургуулиадад илүүтэйгээр олгож буй болно. Хэрвээ зөвлөгөө өгөх төвөөс санал болговол тусгайлан багштайгаар чех хэлний хичээл нэмэлт цагаар заалгах, сэтгэл зүйчээс зөвлөгөө авах, мөн туслах багшийн дэмжлэг авах эрхтэй болж байгаа.

Гадаад иргэдийн хэлний бэлтгэлд өөрчлөлт оруулахыг төлөвлөж байгаа Ирээдүйд чех хэл хоёрдагч хэл нь болох хүүхдүүд долоо хоногт нэмэлт цагаар чех хэлийг заалгах эрхтэй болох юм.

ЕВРОПЫН ЗӨВЛӨЛ:

Боловсролыг олж авахад хэнд хамгийн хэцүү байдаг

- эдийн засгийн хувьд хүнд эмзэг бүлэгээс гаралтай
- эцэг эх нь боловсролын түвшин доогуур туршлага багатай гэр бүлээс
- үндэсний цөөнхөд хамрагдах гишүүн, цагаач, харьяалагдах эх оронгүй хүн

1) www.unicef.cz НҮБ-ын Хүүхдийн сан, хүүхдүүдэд туслах дэлхийн гол байгууллага, 190 гаруй улс оронд ажилладаг.

www.crdm.cz Чех Хүүхэд залуучуудын зөвлөл нь хүүхэд, залуучуудад зориулсан 97 улсын үндэсний холбоо байгууллагууд нэгдсэн.

www.pravonadetstvi.cz БСШУЯ хүүхэд, эцэг эх, мэргэжилтнүүдэд зориулсан мэдээллийн компани 2015

2) 561/2004 Тоот боловсролын тухай хууль.

ТА НАРЫН ХАРЖ БАЙГААЧЛАН ХЭНД Ч АМАР
БИШ. ГЭХДЭЭ ҮҮНИЙГ ДАВЖ ГАРЧ БОЛДОГ! БҮГДЭД
ТУСЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ОРЧУУЛАГЧ, БУСАД
ДЭМЖЛЭГ ЗӨВӨЛГӨӨ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД БАЙГАА,
ЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС АЙЖ ЗОВОХ ХЭРЭГГҮЙ!³ ГОЛ
НЬ БҮГДГИЙГ ХҮҮХДИЙН САЙН САЙХАН ДЭЭД АШИГ
СОНИРХОЛЫН ТӨЛӨӨ ГЭДГИЙГ САНАХ ХЭРЭГТЭЙ.

Бидний дассанаас
бүх зүйл шал өөр

Намайг юу
хүлээж бол?

Оршин суух зөвшөөрөл? Сургууль?!
Эрүүл мэндийн үйлчилгээ?! Ажил?!
Амьдрах сууц?! Орон гэр?!

Гэрээ санаж
байна.

Би айж
байна!

Би Чех хэл сурч чадах уу?

Бид давж гарч
чадах уу?



Яаж ойлголцох вэ?!

Манай анги олон сурагчтай!

Чех хэлний курс, өөр бусад дэмжлэг хэрэгтэй, хаанаас санхүүжилт олох вэ?

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕЦЭД ЮУ ГЭЖ ЗААСАН:

3 дугаар зүйл: хүүхдийн дээд ашиг сонирхол

Насанд хүрсэн хүмүүсаливаа үйл ажиллагаа-шийдвэр гаргахдаа юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.

20 дугаар зүйл: Ялгаварлан гадуурхалалтыг устгах

Хүүхэд өөрийн гарал үүсэл, шашин шүтлэг, чадвар зэргээс үл харгалзан хүүхдийн бүх эрхээ эдлэх ёстой. Түүний эрх хаана амьдардаг, ямар хэлээр ярьдаг, тэдний эцэг эх нь юу хийдэг, тэрээр эмэгтэй эрэгтэй, ямар соёлоос гаралтай, тэдний гэр бүл эд хөрөнгөтэй эсэх зэргээс үл хамаарна. Ямар ч хүүхэд гадуурхагдаж болохгүй.



3) Гарын авлагын төгсгөлөөс чухал ХАЯГ-уудыг харна уу

1. Боловсрол эзэмших эрх болон заавал хамрагдах боловсрол

Иссовагийн гэр бүл хэдэн сарын өмнө Сирээс дайнаас зугатан Чех улс уруу дүрвэж ирсэн. Тэднийг энд яг ямар байдал хүлээж байгааг мэдэхгүй ба, олон асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй (амьдрах байр, ажил, оршин суух зөвшөөрөл, эрүүл мэндийн хүнд байдал). Тэднийх 4 хүүхэдтэй (6-12 насны), тэдний боловсролыг чухал гэж үзэж байгаа ч одоогоор эхний ээлжинд шийдвэрлэх асуудал нь сургууль биш байлаа. Хамгийн чухал нь чех хэл бөгөөд эцэг эх нь сайн сурч чадахгүй л байгаа харин хүүхдүүд нь тэднээс арай дээр сурч буй. Хүүхдүүд одоохондоо сургуульд явж эхлээгүй зөвхөн чех хэлний курсэд хамрагдаж байгаа.

Хүүхдүүд сургуульд явах хэрэгтэй ч одоогоор түүнийг шийдвэрлэх цаг хүч тэнхээ надад алга.

Би тэдэнд сургууль хайж олоод, бүртгүүлж оруулна гэдгээ огт төсөөлж чадахгүй байна.

Би тэдэнтэй ярилцаж ойлголцож чадахгүй шүүдээ.

Сургууль биднийг хүлээж авахгүй байх гэдгээс айж байна.

Хүүхдүүд боловсрол эзэмших сургуульд хамрагдах эрхтэй гэдгийг битгий мартаарай. Сургуульд заавал хамрагдах нас 6-16 ба энэ насны хүүхдээ сургуульд хамруулаагүй эцэг эх хууль зөрчсөнд тооцооно.⁴

Чех хэлний курс санал болгож байгаа сургууль хамгийн тохиромжтой. Танай ойролцоох сургуулиудын тухай мэдээллийг аймаг эсвэл хотын захиргааны боловсролын газраас авч болно. Ойролцоох сургууль уруу орчуулагчтай очих ба сургууль дээр уулзах цагаа урьдчилан тохирвол сайн.

Өөрийн эрхтэй танилцаж түүнийг эдлэхээс санаа зовох хэрэггүй. Мөн өөрийн үүрэгтэй танилцаж, биелүүлэхийг хичээх хэрэгтэй.⁵ Сургууль бүр өөрийн дүрэмтэй ба Эцэг эхийн (хууль ёсны асран хамгаалагч) үүргийг мэдэхэд илүүдэхгүй.


Гадаад иргэдэд тусладаг байгууллага, боловсролын талаар зөвөлөгөө тусалцаа үзүүлдэг байгууллагаас тусалмж дэмжлэг хүсээрэй.⁶

4) Боловсролын тухай хууль 36-р зүйл заавал эзэмших боловсролын тухайн зохицуулна

5) Боловсролын тухай хууль 21-р зүйл эцэг эхийн (хүүлийн төлөөлөгчийн) үүргийн тухай зохицуулна

6) ХОЛБОО БАРИХ бүлгийг харна үү

7) Боловсролын тухай хуулийн 20-р зүйлд идаад иргэдийн боловсролын болон чех хэлний бэлтгэлийн тухай заасан



Сургуульд хичээл явагдаж буй хэлийг ойлгохгүй, төрөлх хэл нь бусад сурагчдаас өөр хүүхдүүдэд сургууль чех хэлний курс болоод бусад өөр дэмжих арга хэмжээнүүдийг авах ёстой (дэлгэрэнгүйг дараагийн бүлгүүдээс харна уу). Бага сургуульд хүүхдийг үнэ төлбөргүйгээр хамруулж гишүүчлэн авахыг сургуулийн захиргаа, мөн аймгийн захиргаа байгууллагаас шийдвэрлэдэг.⁷ Туршлага дээр энэ хэлний бэлтгэлийг сургуулийн захирал шийдвэрлэдэг ба оновчтой санааг дараах линкээс харна уу.
www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/financovani-kurzu-cestiny.

Хэлмэрчлэх үйлчилгээг албан ёсны орчуулагчаас гадна комунитны хэлмэрчид буюу шилжин суурьшигчдийн хэлний бүлгийн хэлмэрч эсвэл соёл хоорондын ажилчид гүйцэтгэдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс олж харна уу
www.meta-ops.cz/komunitni-tlumoceni
а www.interkulturniprace.cz.

Харилцааг хялбарчлах аргуудыг эндээс харна уу www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/informace-pro-rodice-jazykove-verze а slovník.interkulturniprace.cz/

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

28 дугаар зүйл: Боловсрол эзэмших эрх

Бүх хүүхэд үнэ төлбөргүй суурь боловсрол эзэмших эрхтэй. Сургуулийн дүрэм хүүхдийн нэр төрийг хүндэтгэх ёстой. Хүүхдийн эрхийн тухай конвенц нь боловсролыг үнэт зүйлс болгон хүндэтгэх ба түүний дотор бүх хүүхэд хүрч чадах боловсролын хамгийн дээд түвшинд хүрэхийг дэмждэг.

29 дугаар зүйл: Боловсролын зорилго

Хүүхдийн хүртэж байгаа боловсрол нь түүний авъяас чадварыг хөгжүүлж хувь хүн зүгээс хөгжин дэвшихэд нөлөөлөх үүрэгтэй. Боловсролоор хүүхэд өөрийн ойр орчинг эрхэмлэж сурахаас гадна хүний үндсэн эрх соёлыг хүндэтгэж сурахад чиглэнэ. Боловсрол нь хүүхэд аюулгүй орчинд амьдрах боломжийн бүрдүүлэхэд нөлөөлөх үүрэгтэй.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИНД ЮУ ГЭЖ ЗААСАН:

36 дугаар зүйл

Сургуульд заавал хамрагдах ёстой хугацаа сургуулийн 9 жил ба тодорхой шалтгаанаар сургуульд хамрагдах насыг 17 хүртэл сунгаж болно. Энэ үүрэг нь:

- БНЧех улсын иргэн
- ЧУ-д 90 дээш хоногоор оршин суугаа ЕХ орны иргэн
- ЧУ-д 90 дээш хоногоор оршин суугаа байнгын оршин суух зөвшөөрөл болон бусад бүх төрлийн оршин суух зөвшөөрөлтэй иргэд.
- олон улсын хамгаалалт хүссэн түүнд оролцож байгаа иргэдэд хамааралтай

20 дугаар зүйл

ЕХ орны иргэд боловсролын системд хамрагдах нөхцөл нь ЧУ-ын иргэдтэй ижил

Бусад улсын иргэдийн хувьд:

- бага сургуульд
- сургуулийн хоол үйлчилгээ, сургуулийн зохион байгуулж байгаа дугуйлан курзд хамрагдах (бага, дунд сургуульд хамааралтай)

ЧУ-д оршин суух зөвшөөрөлтэйгөөр амьдарч байгаа иргэдийн хувьд:

- дунд болон дээд мэргэжлийн боловсролд хамрагдах

БНЧУ-д олон улсын хамгаалалт хүссэн, олон улсын хамгаалалт авсан, түр хугацааны эсвэл нэмэлт хамгаалалт авсан иргэд, мөн судалгааны зорилгоор 90 дээш хоногоор оршин суугаа иргэдийн хувьд:

- сургуулийн өмнөх боловсролд хамрагдах,
- анхан шатны урлагийн сургууль,
- хэлний сургуульд,
- сургуулийн үйлчилгээнд хамрагдах.

2. Сургуульд сурагчийг бүртгэх цед юу хүсэж, шаардаж болох

Исса гуай хүүхдүүдийнхээ сургуулийг шийдвэрлэхээр шийдсэн ба хэлмэрч олж чадсаны үндсэн дээр хүүхдүүдтэйгээ хамт гэрийнхээ ойролцоох сургууль уруу очиж асуухаар боллоо. Сургуулийн захирал эмэгтэй тэднийг урьдчилан цаг тохироогүй ирэхэд гайхсан ч тухайн үед завтай байлаа. Харамсалтай нь төд удалгүй гол асуудал нь чех хэл болохыг олж мэдсэн захирал Исса гуайд одоогоор хүүхдүүдийг бүртгэхгүй, чех хэл сурсаны дараа дахин ирээрэй гэв. Мөн охидууд үсээ хаасан алчуур/гивлүүр зүүдэг нь сургууль дээр жишээ нь биеийн тамирын хичээлийн үед төвөгтэй байж болох талтай гэхийн зэрэгцээ иймэрхүү сурагчидтай хэрхэн харилцах талаар туршлагагүй гэдгээ тааламжгүй байдлаар илэрхийлэв.

Сургуульд орох бүртгэлийг бичгээр өгөх шаардлагатай. Сургууль таны хүүхдийг сургуульд авахгүй тохиолдолд энэ тухай шийдвэрийг танд бичгээр явуулах үүрэгтэй. Шийдвэрийн эсрэг аймгийн захиргааны боловсрол хариуцсан хэлтэст давж заалдах гаргаж болно.

Чех хэл мэдэхгүй гэх шалтгаанаар нь хүүхдийг сургуульд авахгүй байж болохгүй! Сургуулийн тусгай зөвөлгөө өгөх төв (сэтгэл зүй, тусгай боловсролын зөвөлгөө өгөх төв)-д хандаж зөвөлгөө авахад тустай. Тухайн зөвөлгөөгөөр жишээ нь таны хүүхэд хэлний бэрхшээлээс шалтгаалан тусгай хөтөлбөр хэрэгтэйг бичсэн зөвлөмж хийж өгдөг. Тусгай зөвөлгөө өгөх төвийн үүргийн тухай дэлгэрэнгүйг 11 дүгээр бүлгээс харна уу.

Сургуульд явж, найзуудтай болмоор байна, үргэлж гэртээ байхаас уйдаж байна.

Би үүнийг зохион байгуулж чадсан ч ингэж төгслөө?!

Сургуулиас өөр газар хаана чех хэлийг сурах гэж? хүүхдүүдэд чех хэл сургах дээр сургууль ямар нэг зүйл хийдэг баймаар?

Хүүхдүүдээ иймэрхүү хандалагатай сургуульд явуулахаас санаа зовж байна. Бүх сургууль дээр ийм байдаг юм болов уу?

Алчуур, гивлүүргүй явахаас ичиж байна, миний гивлүүрээс болж ангийнхан маань намайг шоолно гэж үү? Заримдаа автобусанд намайг шоолж байгаа нь надад хангалттай байхад.

ЧУ-ын хуулинд алчуур, гивлүүр зүүх талаар ямар нэг заалт байхгүй ба энэ тухай сургуулийн дотоод дүрэмээр зохицуулах юм. Гэвч энэ дотоод дүрэм нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг баримтлан хүндэтгэх үүрэгтэй.

ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД НЬ:

- чех хэлний нэмэлт хичээлийг хоёр дугаар хэл мэтээр заах
- туслах багшийг холбож өгөх
- харьцуулсан/хувийн төлөвлөгөөг ашиглах
- эцэг эхтэй харилцаа тогтоох

Дэлгэрэнгүйг мэдээллийг

www.inkluzivniskola.cz/cizinec-v-ceske-skole-aneb-organizace.

Сургуулийн захирал сургуулийн багтаамжаас шатгаалаагүйтохиолдолд өөр ямар ч нөхцөлгүйгээр хүүхдийг сургуульд авах ёстой.⁸

Хүүхдийг сургууль бүртгэж аваагүй тохиолдолд бичгээр энэ шийдвэрээ гаргасан байх ёстой.⁹

Сургуулийн хувьд та зохих арга хэмжээг авах хэрэгтэй. (энэ тухай дэлгэрэнгүйг дараагийн бүлгүүдээс харна уу) Хэлний эсвэл өөр бэрхшээлтэй хүүхдүүдийг зарим тохиолдолд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүд мэтээр тооцох шаардлагатай байдаг.¹⁰

Сурагчийг сургуульд авах үед багш нарын хурал хийх шаардлагатай ба багшийг сурагчын онцгой байдалтай танилцуулж стандартны бус нөхцөл байдлыг шийдвэрлэх ажилд хангалттай дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай. Сургууль ангид тохиолдож болох нөхцөлд танд туслах мэргэжилтнүүд эсвэл тодорхой санаануудыг www.inkluzivniskola.cz порталд байх материалуудаас олж мэдэж болно.¹¹

Иймэрхүү онцгой үед жишээ нь Лалын шашинт охины алчуурыг шийдвэрлэх практикбодит арга гэвэл, Жишээ нь эцэг эхтэй нь дүрэм журамын талаар тохиролцох - охны царай харагдахуйц байх ёстой ба биеийн болон хөдөлмөрийн хичээлийн үед сайтар зангидсан байх гэх мэт (1 дүгээр бүлгээс олж харна уу).

Эцэг эхтэй хийх ярилцлаганд бэлтгэхдээ дараах линкээс www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/prijimaci-pohovor өөрөөр гадаад иргэдийн интеграцид зориулсан туслах материал ашиглах боломжтой www.cicpraha.org/upload/soubory/Komunikace/Komunikace-prirucka-2015_WEB.pdf

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

14, 30 -р зүйл: Соёл, хэл, шашинтай байх эрх

үгсаатан, шашны болон хэлний ялгаатай цөөнхийн хүүхдүүд өөрийн гаралаас өөр орчинд амьдарч буй тохиолдолд өөрийн үндэсний соёл, шашнаа шүтэх, төрөлх хэлээрээ ярих эрхтэй.

Хүүхэд итгэж, шүтэх эрхтэй буюу тэдэнд ойр байдаг зүйл нь бусдын эрх чөлөөг хязгаарлаагүй тохиолдолд шашны зан үйлээ үйлдэх эрхтэй. Хүний шашин шүтлэг, итгэл үнэмшилээ харуулах эрх чөлөө нь зөвхөн хуульд заасан болон олон нийтийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх чөлөөг зэргээр хязгаарлагдан байж болох юм.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИНД ЮУ ГЭЖ ЗААСАН:

16 дугаар зүйл

Хичээлийн тусгай хэрэгцээтэй сурагч гэдэг нь өөрийн боловсрол эзэмших эрх, боломжийг эдлэхийн тулд дэмжлэг арга хэмжээ авах хэрэгтэй буй нэгнийг ойлгоно. Дэмжих туслах арга хэмжээ нь хүүхэд, сурагч, оюутнуудын эрүүл мэнд биеийн байдал, соёлын онцлогт орчин, амьдралын нөхцөлд тохирсон боловсролын үйлчилгээ сургалтыг хүргэх явдал. Хичээлийн тусгай хөтөлбөртэй хүүхэд, сурагч, оюутнууд нь сургууль болон сургалт явуулдаг төвүүд дээр дэмжлэг туслалцааг үнэ төлбөргүй авах эрхтэй.

20 дугаар зүйл

Гадаад иргэдийн хүүхдүүд бага сургуульд хамрагдах эрхтэй үнэ төлбөргүй бэлтгэл гишүүнчлэгдэх эрхтэй ба үүнд сурагчидын хэрэгцээнээс хамааран хэлний нэмэлт хичээл авах эрхтэй. Бэлтгэл үйл ажиллагааг аймгийн зохих алба ихэнхдээ хотын дүүрэг, захиргаа сургуулийн удирдлагатай хамтарч зохион байгуулах үүрэгтэй. Боломж тохиолдолд сурагчдийн ирсэн оронтой хамтран (зөвхөн Европын холбооны улс орнуудад хамаарна) төрөлх хэл, соёл, сургалтын дэмжлэг үзүүлэх ба энэ дэмжлэгийг бага сургуулийн хичээлийн хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.¹²

8) Боловсролын тухай хууль 21-р зүйл 7 бүлэг сургуулийн үүргийн тухай зохицуулна.

9) Шийдвэрт хавсаргах материал болон даваж заалдах боломжийг захиргааны журам зохицуулна (500/2004 тоот хууль).

10) Боловсролын тухай хууль 16-р зүйлээр ийм суралцагчийн хэрэгцээг зохицуулна.

11) ХОЛБОО БАРИХ бүлгийг ашиглана уу

12) Гадаад иргэдийн боловсролын тухай боловсролын хуулийн 20 -р зүйлийг хандуулсан.

3. Хэд дүгээр ангид хувиарлах - хэлний чадварын түвшин эсвэл нас шийддэг үү?

Мариам (12 настай) 10 настай байхдаа эцэг эхийн хамт Иракаас ирсэн. Гэр бүлээрээ олон улсын орогнол буюу цагааачлал авсан мөн 400 цагийн үнэ төлбөргүй чех хэлний курсэд хамрагдах эрх авсан. Зуны турш курсын зөвхөн хэсгийг сурсан ба удалгүй эцэг эхийн хамт өөр хот уруу нүүснээр хичээлээ үргэлжүүлэх боломж олдоогүй. Түүний чех хэлний түвшин доогуур гэсэн шалтгаанаар шинэ сургууль дээр нэг дүгээр ангид хувиарласан. Гэвч одоо бичмилээр сайн бичиж бусад хичээлээ сайн сурч байгаа. Гэхдээ өөрөөсөө бага насны ангийнханыхаа дунд амаргүй байх ба бусдаас өөр сонирхолтой болохоор хэнтэй ч найзлаж ойлголцохгүй байлаа.

Чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаа/ дугуйланг бүх сургууль зохион байгуулдаг ба дэлгэрэнгүйг сургуулийн вэб хуудснаас олж болно. Хүүхэд залуучуудын чөлөөт цагт зориулан дугуйлан, нэмэлт сургалт хичээл явуулдаг байгууллага, хүүхдийн төвүүд байдаг.¹³

Хэрвээ хүүхэдтэй тань хандаж буй сургуулийн хандлагатай та санал нийлэхгүй тохиолдолд багш нарын зөвөлгөө өгдөг цагаар багш тус (сургуулиудын веб хуудсанд бичсэн байдаг) бүртээ эсвэл асуудлыг хамтын арга замаар шийдвэрлэхийн тулд сургуулийн захиралтай уулзах боломж байдгыг санаарай. Уулзалтын тухай өмнө нь утсаар эсвэл э-мэйлээр тохирвол зүгээр. Мөн тогтмол болдог эцэг эхийн хуралд оролцох нь анги хариуцсан багштай хүүхдийнхээ сурлага, сургууль дээрх байдлыг ярилцах боломжийг олгодог.

Надад их ичгэвтэр байгаа. Надад ойлгоцох найз байхгүй (чех хэлийг би хэлээгүй!). Хичээлд явах сонирхол алга.

Суралцагчийг хэд дүгээр ангид хувиарлахыг сургуулийн захирал шийдвэрлэх бүрэн эрх мэдэлтэй. Энгийн тохиолдолд сурагчийн өмнө нь хэд дүгээр ангид сурч байснаар анги хувиарлах ба харин сурагч хичээл явагдах хэлийг ойлгохгүй тохиолдолд хэлний түвшинээр шийдвэрлэнэ.

Шууд сурагчийн хэлний чадвараас болж хэд хэдэн анги доошлуулж хувиарлахаас зайлсхийх хэрэгтэй. Ихэнх тохиолдолд энэ нь буруу шийдвэр болохоо хожим нь харуулдаг. Хүүхдийн сайн сайхны төлөө гэвэл үе тэнгийнхний дунд тэдний дэмжлэгээр чех хэлийг хоёр дугаар хэл мэтээр явуулах юм.

Линкийг харна уу www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/zarazeni-do-rocniku.

Анхаар: Чех хэлийг хоёрдугаар хэл болгож заах нь Чех хүнд чех хэлийг заахаас эрс ялгаатай юм. Чех хэлний талаар дэлгэрэнгүйг дараагийн 4 дүгээр бүлгээс харна уу.

Чөлөөт цагийн үйл ажиллагаанаас бусад шийдвэрлэх арга байдаг нь дээд ангийнхантай чөлөөт цагийн үйл ажиллагаар дамжуулан холбож өгч болох ба жишээ нь дээд ангийнханы явдаг дугуйлан курсыг зөвлөх. Зарим нэг санаануудын талаар дараах линкээс олж харна уу www.inkluzivniskola.cz/pedagogicka-prace-s-diverzitou/prace-s-kolektivem.

Нэгдүгээр ангийн эхний хэсэгт чех хэл, бичиг, унших чадвар гээд бүх зүйл сайн явж байсан ч одоо насны зөрүү асуудал гаргах нь их болсон.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

22 дугаар зүйл: Дүрвэгсэдийн статус болон эрх

Хэрвээ хүүхдүүд дайны улмаас эсвэл мөрдөн мөшгөгдсөн гэх шалтгаанаар өөрийн эх орон төрсөн гэрээ орхиж гарахаас аргагүй болсон тохиолдолд дүрвэгсэд статус авна. Ийм хүүхдүүд бусад хүүхдүүдийн ижил эрхтэйгээс гадна тусгай тусламж болон хамгаалалт авах эрхтэй байдаг.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИНД ЮУ ГЭЖ ЗААСАН:

16-дугаар зүйл

Нийгмийн эмзэг бүлэгт хуулийн дагуу эмзэг бүлгийн хүмүүсээс гадна орогнох цагаач эрх авсан, орогнол цагаач хүсэн өргөдөл гаргасан, олон үслын хамгаалалт авсан хүмүүсийг хамруулан ойлгоно. Ийм эрх зүйн статустай хүмүүс нь дэмжлэг туслалцаа авах эрхтэй.

Шийдвэр гаргах үедээ сурагч бага сургуулийг 17 настай дүүргэх ёстойг харгалзана уу (хамгийн оройтохдоо 18 нас хүртэл¹³). Бага сургуулийг төгсөх талаар дэлгэрэнгүйг 9 дүгээр бүлгээс харна уу.

13) Дэлгэрэнгүйг ХОЛБОО БАРИХ бүлгээс харна уу

14) Бага боловсролыг дуусгах нөхцөлийг боловсролын тухай хуулийн 55 зүйлээр зохицуулна

4. Хэлийг эзших нь цндэс

Вьетнамаас ирсэн арван нэгэн настай Пхам хэдэн сарын өмнөөс сургуульд явж эхэлсэн ч хичээл дээр идэвхгүй анхаарал тавьхгүй, хичээлээ ойлгож амжихгүй болсон учраас багш тэрийг ангийн ар талын ширээнд суулгасан. Багшид хичээл дээр ч анхааралгүй, чех хэл ч ойлгохгүй сурагчийг харж уцаарлахгүй байх нь амар байлаа. Мөн Пхамын хувьд урд талын эгнээнд бусдын анхаарлыг татахгүй болсондоо баярлаж байв. Тэрээр хичээлийн жилийн төгсгөлд дүн ч гаргуулж чадсангүй.

СУРАГЧ БОЛОН ТҮҮНИЙ АСУУДЛЫГ АРЫН ЭГНЭЭНД ШИЛЖҮҮЛЖ «ЦЭВЭРЛЭГЭЭ» ХИЙХ НЬ БОДИТ БАЙДАЛ ДЭЭР ХЭНД ТУСТАЙ ВЭ?

Хүүхэд хичээл явагдаж байгаа хэлний бэрхшээлтэй бол сургууль дээр өөрийн мэдлэг боловсролоо ашиглахын тулд энэ байдлаа цаг алдалгүй нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй. Сурагч нийтдээ 70 цагийн хэлний бэлтгэлийн эрхтэй байдаг¹⁶ ба үүнийг аймгийн захиргааны боловсролын хэлтэсээс тодорхой сургуулиудад үүрэг болгон явуулдаг. Бэлтгэл курс явуулдаг сургуулиудын жагсаалтыг аймгийн захиргааны веб сайтаас харна уу.

Боловсрол-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвд хандаарай. Таны хүүхэд хэлний бэлтгэлд хамрагдах хэрэгтэй гэсэн тодрохойлолтыг хийж өгөх боломжтой. Боловсрол-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх газар сургуулийн зөвлөгөө өгөх төвүүдэд багтах ба үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг.¹⁷ Боловсрол-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвд очих нь хэвийн үзэгдэл юм шүү. Илүү тодорхой мэдээллийг 11-р бүлгээс үзнэ үү.

Боловсролын тухай хуулийн дагуу гадаад хүмүүс гарал үүсэл, оршин суух зөвшөөрөл, эрх зүйн статус харгалзахгүйгээр заавал эзэмших боловсрол, сургуульд чех хэлийг сурах эрхтэй байна. Гэхдээ бодит байдал дээр зарим тохиолдол хуулиас өөрөөр хэрэгждэгийг тооцох хэрэгтэй. Энэ нь мэдээж зөв байдал биш бөгөөд энэ тухай мэдэгдэж анхааруулах ёстой. Заримдаа 70 цагийн хэлний бэлтгэлд хамрагдах боломж байхгүй, зарим бэлтгэл курс хичээлийн багтаамж болоод чанар муу байдаг.

Энэ нь надад амар л байна, гэхдээ ийм байдлаар би юу ч сурахгүй байх. Одоо хичээл дээр урдуур юуны тухай яарилцаж байгааг би ерөөсөө ойлгохгүй.

Сурагчийг сургуульд явж эхлэхээс нэг долоо хоногийн өмнө сургуулийн захирал чех хэлний хичээл хэрхэн явагдах тухай танд мэдэгдэх үүрэгтэй.

Хичээл явагдаж буй хэлийг ойлгохгүй байгаа сурагчид хичээл дээр дэмжлэг авах эрхтэй. Хоёр дах хэл болох Чех хэл дээр дэмжлэг үзүүлэх нь тун чухал дэлгэрэнгүйг www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/kurzy-cestiny-pro-cizince.

Чех хэлийг хоёрдах хэл мэтээр сургах нь тусгай арга зүйтэй. Сургачийг доод ангид хувиарласанаар хэлний бэлтгэл хийж байна гэсэн үг биш. Сурагчид чех хэлний анхан шатыг сурч хялбар аргаар өөрийгөө илэрхийлж, хоорондоо ярилцаж ойлголцох сурах нь чухал. Ингэж сурахын тулд тэндэнд тохиромжтой аюулгүй нөхцөл, мэргэжлийн хүний анхаарал хандлага хэрэгтэй. Энэ нь тэдэнд чех хэлийг хоёрдах хэлээ болгон сурах (хувийн эсвэл курсэд) баталгаа болно.

Сургуулиас үнэ төлбөргүй ба нэн даруй дэмжэх арга хэмжээг үзүүлэх үүрэгтэй.¹⁵ Сурагч хичээлийн сэдвийн тайлбарыг ойлгохгүй бол түүний түвшин хэрэгцээнд тохируулан хичээлийн тайлбарыг өөрчилж үзээрэй. Мөн бодит туслах материал зүйлс, толь бичиг, ялангуяа сурагчыг өөрийг нь оролцуулсан сургалтын арга зүйг ашиглаарай. Дараах вэб сайтаас харна уу www.inkluzivniskola.cz/zapojeni-do-vyuky.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

16 дугаарзүйл

Бага болон дунд сургуулийн оюутан, сурагчийн сургалтын тусгай хэрэгцээг сургуулийн зөвлөгөө өгөх төвөөс оношлонтодорхойлно.

Сургалтын тусгай хэрэгцээтэй бага болон дунд сургуулийн хүүхэд, сурагч, оюутнуудийн хэрэгцээт нөхцөлийг бүрдүүлсэн тэдний хувийн боловсролын түвшин боломжид тохирсон арга зүй ба түвшинтэй хичээл сургалтыг авах эрхтэй. Мөн тэд ийм тусгай боловсрол боломжит нөхцөлийг бий болгох сургуулийн зөвлөгөө өгөх төвийн тусламжийг авах эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй, тахир дутуу сурагч оюутнууд сургуульд элсэн орох болон сургуулиас чөлөөлж гаргахдаа тэдний хувийн хэрэгцээнд нь таарамжтай нөхцөлийг бүрдүүлнэ.

БСШУЯ-НЫ 48/2005 ДУГААРТ ТОГТООЛ

Аймгийн захиргаанаас тухайн нутаг дэвсгэрт хэлний бэлтгэлийг гадаад иргэдэд хуулийн дагуу заавал эзэмших боловсролыг явуулж байгаа сургуулиудад үнэ төлбөргүй зохион байгуулна.

Аймгийн захиргаанаас эдгээр сургуулиудийн жагсаалтыг нийтэд мэдэгдэнэ.

Томилогдсон сургуулийн захирал хэлний бэлтгэлийн хичээлийн ангийг гаргаж сурагч хамгийн багадаа 70 цагийн хэлний бэлтгэлийг хичээлийн жилийн 6 сараас ихгүй хугацаанд багтаан сурна.

Хойд талын эгнээний ширээнд сурагчийг суулгах нь мэдээжийн хэрэг дэмжлэг үзүүлж буй арга биш бөгөөд хичээлийн турш сурагчийг сурах бичиг толь бичгийн хамт тусгаарлан суулгах нь мөн л туслах арга биш юм. Сурагчдийг тодорхой түвшинчилсэн даалгавраар чадваржуулах хэрэгтэй ба даалгавар бүрийг гүйцэтгэсний дараа сурагчдад гүйцэтгэлийн талаарх санал бодлоо хэлээрэй. Ийм санаа бодол нь дараа сурлагын эцсийн байдлыг дүгнэх үндэс болдог. Тогтмол шат шатаар ахих түвшинг анхаарч харах нь танд үр ашигаа өгнө. Энэ аргыг хэрэгжүүлэхэд танд портфель эсвэл боловсролгүй тэнцвэржүүлэн тогтборжуулах төлөвлөгөө туслаж болно. дэлгэрэнгүйг www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/vyrovnavaci-plan.

Тэвчих арга байгаагүй, би яахаа мэдэхгүй байна .

15) Боловсролын тухай хуулийн 16-р зүйлээр зохицуулна

16) Ойрын хугацаанд цагийг нэмэхээр төлөвлөж байгаа.

17) ХОЛБООБАРИХ бүлэг зөвлөгөө өгөх төвүүдийн тухай олж мэдээрэй.


5. Эцэг эх ч өөрсдийн цэрэгтэй

Украинаас ирсэн Олгаг хичээлд хэрхэн идэвхитэй оруулах талаар ангийн багш нилээд хугацаанд бодож байлаа. Олга (13 настай) чех хэл нь хурдан сайжирсан боловч зарим үед хичээл дээр ядарсан байдалтай гэрийн даалгавраа хийхгүй бэлтгэлгүй ирэх ба сүүлийн үед хэд хэдэн цагийн таслалтай байгаа болхор түүний сурлага муудаад хичээлээс хоцрож байна. Олгагийн эцэг эхтэй холбоо барих оролдлого бүтэлгүй байгаа ба - тэд сурагчийн дэвтэрт бичсэн багшийн тэмдэглэлийг уншихгүй, эцэг эхийн хуралд ч ирэхгүй байлаа. Сурагчийн ар гэрийн байдал зүгээр эсэх дээр ангийн багш санаа зовож байлаа.

Эцэг эх бүр өөрийн хүүхдэд боловсрол эзэмшүүлэх үүрэгтэй¹⁸. Хүүхдээ заавал сургуульд хамруулах үүрэгтэй ба үүнтэй холбоотой сургуулийн багш, захиралын зохион байгуулсан уулзалт хуралд оролцох үүрэгтэй. Танай хүүхдийн хичээлийн ирцтэй холбоотой чухал үйл явдалын тухай мэдэгдэх үүрэгтэй ба хүүхэд сургуульд очих боломжгүй бол энэ талаар мэдэгдэж тайлбарлах ёстой.

Хэрвээ та сургууль уруу очих завгүй бол багштай емайл эсвэл утсаар холбогдож ярилцаж болно. Тогтсон уулзалт хуралд очих боломжгүй бол заавал уучлалт хүсээрэй.

Танай хүүхдийн сурлага ямар байгаа, сургууль дээрээ ямар байдалтай байгааг үргэлж сонирхож байгаарай. Танай хүүхэд хүнд түвэгтэй байдалд орвол таны тусламж дэмжлэг түүнд хэрэгтэй.



Хүүхэд сургуульд орох үед эцэг эхийг сургуулиас сургуулийн дотоод дүрэм журамтай танилцуулах хэрэгтэй ба дүрмийгбусад хэлэнд орчуулан бичгээр танилцуулвал сайн. Боломжтой бол биеэр уулзаж ярилцаарай. Үргэлж орчуулга хийлгэхэд хэцүү байдаг ба санаа авах материалуудыг дараах линкээс харна уу www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/informace-pro-rodice-jazykove-verze.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЭД ЮУ ГЭЖ ЗААСАН:

18 дугаар зүйл: Эцэг эхийн хариуцлага

Хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг эх хоёулаа хүүхдийн дээд ашиг сонирхол нь чиглэх шийдвэр гаргаж хариуцлага хүлээнэ. Орлогчгч улсуудын засгийн газар эцэг, эх хүүхдийн хүмүүжил болон хөгжилд гол хариуцлага үүрэхийг хүлээн зөвшөөрнө. Улс эцэг эхэд өдөлмөрлөх боломж гарагах үүднээс асрамжийн алба, газрын үйлчилгээг хүргэх үүрэгтэй.

27 дугаар зүйл: Зохистой амьдралын түвшин

Хүүхэд асран хүмүүжүүлэх эцэг эх буюу тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид өөрийн боломж ба эдийн засгийн чадварын хүрээнд хүүхдийн хөгжилд шаардлагатай амьдралын нөхцөлийг хангахад үндсэн хариуцлагыг хүлээнэ.

Эцэг эхийн хурлыг захирал эсвэл сургуулийн хүмүүжилийн буюу нийгмийн ажилтан гэх мэттэй хамтатгах үедээ зарим нэг гадаад иргэдэд тусладаг төрийн бус байгууллага ажилтан болон хэлмэрчийн үйлчилгээ дэмжлэгийг авч болно.

Хэрвээ цаашид эцэг эх үүргээ биелүүлэхгүй бол Боловсролын тухай хууль болон сургуулийн дотоод дүрмийн дагуу тухайн нөхцөлд авдаг арга хэмжээг аваарай.

Ийм төрлийн харилцаа нөхцөлд та бэлэн байх үүднээс зарим нэг бэлэн материалыг ашиглаж болно, жишээлбэл www.cicpraha.org/upload/soubory/Komunikace/Komunikace-prirucka-2015_WEB.pdf.

Сурагчийн аав ээжийг надтай хэрхэн яаж холбоо бариулахаа одоо мэдэхгүй боллоо. Тэднийг үүргээ биелүүлэхийг шаардаж болох уу?!

6. Анги давтан сурах нь шийдэлт биш

Хэдийгээр харьяалалынхаа дагуу бага сургуульд хэлний бэлтгэлд хоёр жил хамрагдсан ч бүх хугацааны туршид Хунг сургуулиас тусгай тусламж дэмжлэг авч байсангүй. Түүний гол асуудал нь чех хэл огт мэдэхгүй явдал байлаа. Найман настай нэгдүгээр ангид орсон хэдийч хичээлээ ойлгоогүйн улмаас ангийнхныгаа гүйцэж чадаагүй. Хунгийн ээж сургуультай холбоо баридаг боловч чех хэлээр зөвхөн анхан шатны түвшинд ойлголцож хэдхэн үг мэддэг болохоор хэлмэрчгүйгээр хүүгийн сургалтын талаар ярилцах боломжгүй. Хунг зөвхөн ойр зуурыг ойлгож мөн түүний үгсийн сан ядмагхан, хаяа зарим тохиолдолд өгүүлбэр хэлж чаддаг. Математикийн хичээлд сайн боловч хэн ч түүнийг нь хөгжүүлээгүй орхисон. Хичээлийн жилийн дундуур сахилгагүйтэж зарим нэг хүмүүжлийн асуудал гаргаж хичээлийн жилийн эцэст хичээл дээр сонирхолгүй назгайран сууж зүүрмэглэх болсон. Нэгдүгээр анги давтан сурахаас аргагүй болсон.


ЕР НЬ БЭЛТГЭЛ АНГИ ТӨДИЙГҮЙ, АНГИ ДАВТАН СУРГАХ НЬ ОНОВЧТОЙ ШИЙДВЭР БИШ. ОНДОО ЭХ ХЭЛТЭЙ СУРАГЧИЙГ ДҮГНЭХ ТАЛ ДЭЭР БИД БУСАД СУРАГЧИДТАЙ ХАРЬЦУУЛАХААСАА ИЛҮҮТЭЙГЭЭР ЗӨВХӨН ТЭДНИЙ ХУВИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ НЬ ЧУХАЛ.

Суралцагч бүр үнэлж, дүгнүүлэн дараагийн ангид дэвшин сурах эрхтэй. Сурагч дүгнүүлэх боломжгүй эсвэл зарим хичээлийн нөхцөлийг хангаагүй тохиолдолд анги давтан сурч болно. Бага сургуулийн нэг дүгээр шатанд (1–5 дугаар анги) нэг удаа, хоёр дугаар шатанд (6–9 дүгээр анги) 1 удаа давтан сурч болно.¹⁹

Сургуулиас танай хүүхдийг анги давтан сурахыг зөвлөвөл эхний ээлжинд хичээл дээр түүнтэй хэрхэн ажилласаныг бүх боломжит дэмжлэгийг (жишээ нь хувийн онцлогт нь тохирсон даалгавар, даалгаврын гүйцэтгэлд илүү цаг өгч байсан, тогтворжуулан тэнцүүлэх төлөвлөгөө, үзүүлэн таниулах материал, толь бичиг хэрэглэх боломж, чех хэлний курс г.м) авсан эсэхийг мэдээрэй. Тохиолдож болох асуудлыг шийдвэрлэх цаг хугацаатай байх үүднээс хүүхдийнхээ сургалтын үнэлэлт дүнд цаг тухайд нь анхаарч байгаарай. Хэрвээ та хүүхдийнхээ дүнг зөвшөөрөхгүй тохиолдолд гэрчилгээг гардан авсанаас хойш ажлын 3 өдөрт сургуулийн захирал эсвэл аймгийн захиргааны боловсролын хэлтэст дүнг дахин шалгуулах хүсэлтээ гаргаж болно.²⁰

Хэрвээ сургуулиас эсвэл та өөрөө танай хүүхдийн сургалтын үр дүнг дээшлүүлэхийн тулд туслах багшийн дэмжлэг хэрэгтэй гэж шийдвэл боловсрол- сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвд хандаж туслах багш гаргуулах зөвлөмжийг гаргуулах шаардлагатай.

Хүү маань Чех сургуульд явж байгаа болохоор хэлний хувьд түүнд туслах байх гэж бодсон. Бид өөрсдөө чехээр зөвхөн ойр зуур ойлголцдог учраас хэлний бэрхшээлд нь туслаж хүүгээ идэвхжүүлж чиглүүлэх боломжгүй тэр ч байтугай хүүгийнхээ хичээлийн бэлтгэлд олигтой туслах чадваргүй юм.



Сурагчийн амжилтгүй сурч буйн шалтгаан нь хэлний бэрхшээлээ давж чадаагүйнх үү? сурагчийн мэдлэг чадвар дадал, хувийн ахицыг үнэлэн дүгнэх боломжгүй учраас түүнд дүн тавихгүйгээр шийдсэн үү? Ийм сурагчид сургууль дэмжлэг тусламж хүргэж чадаагүй бол түүнийг анги давтан сургах шийдвэр гаргасанаар хувийн хөгжил дэвшилийг нь сааруулж буй хэрэг гэдгийг байнга санаарай. Хэдэн жил нэг түвшинд ижил ангид суусанаар сурагч чех хэлийг гүйцэд сурч нэг өдөр дэвшилт гаргана гэж үзэж болохгүй. Сурагчдын хувийн чадвар ямар түвшинд хүрэх чадвартай, ямар түвшинд хүрэх гэдгээр нь үнэлэн дүгнэхийг хичээгээрэй. Дараах линкээс харна уу: www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/klasifikace.

Хоёрдагч хэл болох чех хэлний мэдлэгийг дамжуулах явдлаас эхлүүлээд өмнө дурдсан бүхий л арга барилыг цаг ямагт баримтлахад амжилтын үндэс оршдог.

Туслах багшийгн хүсэлтийг хэрхэн яаж гаргах гэдгийг дараах линкээс олж харна уу: www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/asistent-pedagoga.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЮУ ГЭЖ ЗААСАН

16 дугаар зүйл

(6)Тусгай сургалтын хэрэгцээтэй суралцагч,оюутнуудыг үнэлж дүгнэхдээ тэдний хөгжлийн бэрхшээл, хувийн онцлогийг нь харгалзан үзэх хэрэгтэй.

48/2005 ДУГААРТ ТОГТООЛ

15 дугаар зүйл, 6 дугаар бүлэг

Заавал эзэмших боловсролын хүрээнд сургуульд хамрагдаж буй гадаад суралцагчийг үнэлж дүгнэхдээ чех хэлний мэдлэг чадвар түвшин тэндий мэдлэг, чадварт онцгой нөлөөлдөгийг харгалзах шаардлагатай.

Сургалтын материал, сурах бичгийн жагсаалт, чухал хэрэгцээт линк зэргийг олж мэдхийг хүсвэл дараах порталаас харна уу www.inkluzivniskola.cz/cestina-jazyk-komunikace.

7. Бага сургуулиар зогсох ёсгүй

Оливер өөрийн нутгаас Чех Улсад 7 дугаар ангид дэвшин сурах үедээ ирсэн. Чех сургуульд түүнийг дахин 7 дугаар хувиарласан ч жилийн дараа чех хэл, сурлагын байдал нь сайжраагүй учраас 7дугаар ангиа давтан сурах шаардлагатай болов (нийтдээ 3 дах удаагаа). Сургууль түүнд анги давтан суралцахаас өөрөөр ямар ч дэмжлэг тусламж хүрэгсэнгүй. Дараагийн жил анги давтан суралцаж байх хагас жилийн явцад 9 жил бага сургуульд хамрагдах эрхээ эдлэсэн тул тухайн сургуульд үргэлжлүүлэн сурах боломжгүй болсон тухай Оливерийн эцэг эхэд нь гэнэт мэдэгдлээ. Сургуулийн зүгээс түүнд зөвлөхдөө бага сургууль төгссөн байх гэсэн шаардлага тавидаггүй зарим техник мэргэжлийн сургуульд орох эсвэл ажил хийхийг зөвлөлөө. Энд сургууль дээр хангалттай дэмжлэг авч чадаагүйн улмаас өөрийгөө хөгжүүлэх боломжийг олж чадаагүй ухаантай хүүгийн тухай яригдаж байгаа ба түүнд цагаасаа эрт боловсролын системийг орхих аюул тулгарч байна.

ХАНГАЛТТАЙ ДЭМЖЛЭГ АВААГҮЙ, ЗӨВ АНГИ ХУВИАРЛАЛТ ЯВАГДААГҮЙН УЛМААС СУРАГЧИЙН СУРГУУЛЬ ДЭЭРХ 2 ЖИЛ ҮР ДҮНГҮЙ ӨНГӨРСӨН ҮҮ?! ЭНЭ ТОХИОЛДОЛД 9 ЖИЛ СУРГУУЛЬД ХАМРАГДАН ИРЦ БҮРТГҮҮЛСЭН ТУХАЙ ЯРИГДАЖ БОЛОХ УУ? БАГА СУРГААЛИА ДҮҮРГЭСЭН ГЭРЧИЛГЭЭГҮЙГЭЭР 7 АНГИАС СУРГУУЛИАС ГАРАХ НЬ СУРАГЧИЙН ӨӨРИЙН ХҮСЭЛТ ҮҮ? ТҮҮНИЙ ЦААШИДЫН ХЭТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ЮУ ВЭ?

Бага сургуулиа төгсөж чадаагүй сурагчийн хувьд цаашид сурах сургуулийн сонголт нь хязгаарлалттай байдаг. Үндсэндээ сонголт нь голдуу хялбар биеийн хүчний хөдөлмөр гүйцэтгэх, ажил үйлчилгээний мэргэжлийг 2-3 жил сурч төгсөлтийн хуудастайгаар дүүргэх техник мэргэжлийн сургуулиуд. Танай хүүхдэд аль боломж нь тохиромжтойг тухайн сургуулийн хүмүүжил сургалтын зөвлөгч мэргэжилтэн эсвэл тусгай сургалт хүмүүжил, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийн зөвлөгчтэй уулзаж зөвлөгөө аваарай. Мөн хүүхдийнхээ ямар учраас юу сонирхож, хүсэж байгааг асууж сонирхоорой.

Хууль дунд сургуульд суралцах бүртгүүлэх үндсэн нөхцөл нь бага сургуульд хамрагдаж дүүргэсэн байх байдаг ч хамгийн гол шатгаалах зүйл нь тухайн сургуулийн элсэлтэнд тавигдах нөхцөл юм. Улсын бүрэн дунд боловсролын төгсөлтийн улсын шалтгалтаар төгсдөг дунд сургууль бүр 8, 9 дүгээр ангийн дүнгийн жагсаалт болох гэрчилгээг шаарддаг.

Ойлгоход бэрх байдал!

Анги давталтын ачаар гол асуудал болох чех хэл нь сайжирна гэж найдаж байсан. Сургуулийн зүгээс ийм нөхцөл байдлаас болж хүү маань сургуулиас гарахаас өөр аргагүй болно гэж бидэнд огт анхааруулаагүй.

Заавал хүүхдийнхээ сургуульд сурах хуулиар тогтоосон хугацааг сунгаж өгөхийг тухайн сургуулиас сунгаж өгөхийг хүсэх боломжтой ба зөвшөөрөөгүй тохиолдолд аймгийн захиргааны боловсролын хэлтэсээр дамжуулан давж заалдаж болно.²¹ Ингээд ч танд зөвшөөрөхгүй мөн таны хүүхэд техник мэргэжлийн сургуульд үргэлжлүүлэн сурахыг хүсэхгүй бол нэг жилийн үнэ төлбөргүй бага сургуулийн гэрчилгээ авах курсэд бүртгүүлж болно.²² Чех хэлний курсэд сурах бүртгүүлэх талаар дэлгэрэнгүй шинэ мэдээллийг аймгийн захиргааны боловсролын хэлтэс өгнө.

3 удаа 7 дугаар анги давталт?! Хэн ч надад тусалцаа үзүүлээгүй, одоо намайг хөөж байна.

Сургуулийн захирал, багш нарын шийдвэрийн хамгийн чухал нь хүүхдийн сайн сайхан дээд сонирхолын төлөө байх ёстой. Өнөөгийн нийгэмд дунд сургуулийн боловсролыг тиймд хүнд гэж тооцохоо болисон бөгөөд бүгдэд ижил тэгш боломж олгох нь бидний зорилго байх ёстой.

Хүүхэд сургуульд орох үед цаашлаад хэд дүгээр ангид сурахыг хувиарлаж байх үедээ сурагч хамгийн оройтохдоо хэдэн онд 18 нас (эрүүл мэндийн шалтгаанаас хамаарсан тохиолдолд урт байж болно) хүрмэгцээ сургуулиа төгссөн байх ёстойг бодож тооцож байх хэрэгтэй.

Хүүхэд бага сургуулиа ердийн сургуульд байнгын тогтмол горимд үе тэнгийнхэний дунд хамт олон нийгэм орчинтойгоо холбоотойгоор суралцах нь нэн чухал.

Сурагчийн идэвхгүй байдал сурлагын муу дүн нь түүний залуу, сурах дургүй байдлаас шалтгаалах албагүй. Зарим тохиолдолд шалтгаан нь (сэтгэл зүйн дарамт, гэр орны хүнд нөхцөл, гарал угсааны мэдрэмж харамсал) хичээлийн эхэн үеийн сургуулийн зүгээс ирэх эвгүй хандлага нөлөөлж болно (ялангуяа хангалтгүй хэлний бэлтгэл).

Сурагчийг цаашид дараагийн ангид дэвшин сурахад бүх хичээлийг хичээлийн жилийн төгсгөлд дүгнэгдсэн байх ёстой.²³ Сурагчийг дүгнэх дүгнэлтэндээ сурагчын сурлагын амжилтанд түүний суралцаж байгаа хэлний түвшинийг чухалчилан авч үзэх түүний мэдлэгт дутагдаж байгаа эсэх зэрэг нь дунд заавал нөлөөлдөг. Дүгнэлтийг зөв зорилгоор хийхийн тулд дараагийн линкээс харна уу www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/slovni-hodnoceni а www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/vyrovnavaci-plan.

КОНВЕНЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

28 дугаар зүйл: „Сурч боловсрох эрх“

Хүүхэд бүр сурч боловсрох эрхтэй ба өөрийн чадвартаа түшиглэн боловсролын боломжит дээд түвшинд хүрэх бололцоог шаардлагатай бүх арга замаар хүртэх эрхтэй.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИНД ЮУ ГЭЖ ЗААСАН:

55 дугаар зүйл

Заавал хамрагдах боловсролыг дүүргэж чадаагүй сурагчид бага сургуульд үргэжлүүлэн сурах боломжийг суралцагчийн 18 нас хүртэл үргэлжлүүлэхийг тухайн сургуулийн захирал зөвшөөрч болно. Бага сургуулийг эзэмшиж чадаагүй этгээдэд бага дунд сургууль аймгийн захиргаатай зөвлөлдсөний дараа суурь боловсрол эзэмших сургалтыг зохион байгуулж болно.

59 дугаар зүйл

Дунд боловсрол эзэмшихээр сургуульд орохоор өргөдөл гаргагч нь бага сургуульд сурах хуулиар тогтоосон хугацаандаа сурч төгссөн эсвэл хуулиар тогтоосон хугацаанаасаа өмнө төгссөн мөн тодорхой амжилт авъяас чадвар, эрүүл мэндийн байдлаараа сургуулийн элсэлтийн шалгалтын нөхцөлийг хангасан тохиолдолд дунд сургуульд орох эрхтэй. Сургуулийн захирал сургуулийн элсэлтийн тухай шийдвэр гаргадаг.

21) Боловсролын тухай хуулийн 55-р зүйл заавал эзэмших боловсролыг 10 хүртлэх жилээр сунгах тухай зохицуулна

22) Боловсролын тухай хуулийн 55 дугаар зүйл үүнийг зохицуулна.

23) Дэлгэрэнгүйг. Боловсролын тухай хуулийн бага сургуулийн тухай 52, 53, 54 зүйл, дунд сургуулийн тухай 69-р зүйлээр зохицуулна

8. Анги дахь харийг жигших үзэл

Муслим 13 настай эхийнхээ хамт Чеченээс 2003 онд Орос-Чечен
ний хоёр дугаар дайнаас дүрвэж ирсэн ба тэр үед Муслим бага
байсан. ЧУ-д цагаачлал авч, эндээ Чех цэцэрлэг сургуульд явсан.
Багаасаа энд өссөн болоохор Чех хэлийг эх хэл шигээ сурсан.
Сургууль дээрээ ангийнйхаа дунд найзуудтай дунд зэргийн
сурсан энгийн өсөж яваа сурагч байлаа. Гэвч 8 дугаар ангид
байдал өөрчлөгдлөө. Европоор хэд хэдэн удаа террорист халдла-
га болж мөн дайнаас, Исламаас, амьдралын хүнд нөхцөлөөс
зүгтсэн дүрвэгсэдийн давалгаа ирж байлаа. Муслим нэрнээсээ
өөрөөр Лалын шашинтай ямар ч холбоогүй шахуу байхад ан-
гийнханаас зарим нэг сурагч түүнийг нэрнээс нь болж шоглон
гадуурхаж, тэр ч байтугай террорист гэж дуудаж эхлэлээ. Үнэн-
дээ тэд нутагтаа ч лалын шашины хүчтэй итгэгчид биш байлаа.
Сургуулийн зүгээс ангийнханы хандлагыг өөрчлөх арга зам оло-
огүй төдийгүй түүний ээжтэй нь ч асуудлын талаар ойлголцох
боломж арга олсонгүй. Ээж хүүгийнхээ сэтгэл санаа, бие эрүүл
мэндийн төлөө санаа зовж эрс шийд гаргаж хүүдээ гэрийн сур-
галт бүрдүүлж, хүүгийнхээ нэрийг өөрчлөх өргөдөл гаргалаа.


СУРГУУЛИАС ГАРАХ, НЭРЭЭ
ӨӨРЧЛӨХ НЬ ХҮҮХДИЙН ХҮСЭЛ МӨН ҮҮ!?
АСУУДЛЫН ШАЛТГААН НЬ МУСЛИМ
ЭСВЭЛ ОРЧИН ТОЙРНЫХОН?

Хүүхдээ үе тэнгийнхэн хамт олноос нь
тусгаарлана гэдэг хамгийн сүүлд авах эрс ший-
двэр байж болно. Эхний алхамд танд багш нар,
хүмүүжлийн ажилтан зөвлөгч, сургуулийн сэтгэл
зүйч туслах үүрэгтэй ба дараагийн ээлжинд мэр-
гэжлийн байгууллагад хандаж болно.²⁴

Гол нь тулгарсан асуудлаа өөртэй
хадгалах хэрэггүй ба ижил төстэй
проблемийг чех эцэг эхүүд ч
шийдвэрлэдэг.

Энд би нэг өдөр хүүгийнхээ
төлөө ингэж айна гэж санасангүй.

Би хэнд ямар зүйл
хийсэн гэж?!
Би айж байна.



Сургууль дээр бүх хүүхдүүдэд айх аюулгүй найдвартай орчинг бүрдүүлэх нь сургуулийн үүрэг. Ийм орчин бүрдээгүй тохиолдолд шаардлагатай зохих арга хэмжээг авч ийм бололцоог бүрдүүлнэ. Урьдчилсан арга хэмжээ авахаас гадна үзэн ядах үзэл, арьс өнгөөр ялгавралан гадуурхах, алагчлах үзэл гэх мэт гарч ирж болох сэдвүүдийн талаар тодорхой дүрэм тогтоосон байх шаардлагатай. Алагчлах үзлийн талаар бүх сургуулийн хичээлийн хөтөлбөрийн салшгүй хэсэгт оруулсан байх ба цаашлаад шоглон дээрэлхэх, ялгавлалан гадуурхалт зэргийн эсрэг наад зах нь урьдчилан сэргийлэх хөтөлбөрт өөрийн гэсэн тогтвортой байр суурьтайгаар орсон байх ёстой. Сургууль ямар үүрэг гүйцэтгэх, шоглон дээрэлхэх тохиолдол гарсан үед ямар арга хэмжээ авах, яаж таниж ялгах, хэнд хандах зэргийг Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны арга зүйн зааварчилгаанаас олж мэдэж болно. Дараах линк www.inkluzivniskola.cz/zdroje-inspirace/metodicky-pokyn-k-sikane.

Тодорхой нөхцөл байдал гарсан үед сургуулийн зөвөлгөө өгөх төв, урьдчилан сэргийлэгч уруу (ŠPZ) холбоо барьвал зүгээр.

Сургуулийн ажилчид үзэн ядалтаас үүссэн үйл явц тохиолдсон үед ямар үйлдэл хийхээ мэддэг тогтсон дүрэмтэй байх ёстой. Санаа авах линк www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/pravidla-pro-zamestnance-skoly.

КОНВЕНЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

19 дүгээр зүйл:

Бэлгийн хүчирхийлэл бусад хэлбэрийн хүчирхийлэлийн эсрэг хамгаалалт авах эрх

Хүүхдүүд бие бялдар, сэтгэл зүйн хувьд дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалалт авах эрхтэй.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ (БШУЯ)-НЫ АРГА ЗҮЙН ЗААВАРЧИЛГАА

Сургууль нь хүүхэд сурагч бүрийн өмнөөс тэдний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинг бүрдүүлэх хариуцлага хүлээдэг ба эрүүл энх хөгжих боловсрох эрсдэлтэй харилцаа үйл длээс тойрч гарах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Сурган хүмүүжүүлэгч багш ажилтан сурагчдийн дунд дах шоглон дээрэлхэх үйлдэл, хэрцгийгээр хандахаас урьдчилан сэргийлэх, ийм үйлдэлийг таслан зогсоож шийдвэрлэж, хохирогч хүүхдэд анхны тусламж хүргэх үүрэгтэй.

Хавчин гадуурхаж, үл ойшоож, татгалзсан үйлдэл нь насанд хүрсэн хүнийг өөрт болон ойр тойрныхонд аюултай үйлдэл хийхэд хүргэж болдог гэдгийг санаж байх хэрэгтэй.

9. Албан бус боловсрол ч чухал

9 настай Тан бага сургуульд бараг бүтэн жил явсан боловч Чех хэлний хувьд их тааруухан байлаа. Сургуулиуд байгальдах аялал курсээр хичээллэдэг үе таарсан учраас багш түүний ээжтэй холбоо барьж ярилцсан. Эхэндээ Тан-д унтах хэрэгсэл болон байгальдах аялалд хэрэгтэй бусад хэрэгсэл байхгүй учраас ангийнхантайгаа явж болохгүй гэж тайлбарлалаа. Харин Тан үе тэнгийнхэн найзуудтайгаа цагийг өнгөрөөхөд нь дуртай байсан учраас ээж нь хэрэгтэй зүйлс юмыг авсан боловч харамсалтай нь бүх зүйл өөрөөр эргэж захирал болон багш хүү байгальд гараад ямар нэгэн асуудал гарвал хэлний бэрхшээлээс шалтгаалан шийдвэрлэж чадахгүй байх гэсэн шалтгаанаар байгальдах аялал курсэд явахыг нь зөвшөөрсөнгүй.

БАЙГАЛЬ ДАХ АЯЛАЛ
КУРС, АЛБАН БУС СУРГАЛТ, ЧӨЛӨӨТ
ЦАГТ ЗОРИУЛСАН ДУГУЙЛАН СЕКЦИЙН
ЗОРИЛГО ЮУ ВЭ? БАЙГАЛЬ ЦЭВЭР АГААРТ
ХҮҮХДҮҮДИЙН ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЖ
ИЛЭРҮҮЛЭХ, ХҮҮХДҮҮДИЙН ХООРОНДЫН
ХАРИЛЦАА НИЙГЭМД ХАРИЛЦАА ХОЛБОО
ТОГТООХ ЧАДВАРТ СУРАЛЦУУЛАХ ЮМ.
ХҮҮХДИЙГ ХАНГАЛТТАЙ САЙН ОЙЛГОЛЦОХ-
ГҮЙ БАЙНА ГЭХ ШАЛТГААНААР ЭНЭ БО-
ЛОМЖООС ХАСАЖ БОЛОХ УУ?

Чөлөөт цагт зориулсан дугуйлан секцэнд хамрагдах эсэх нь хүүхдийн сонирхол, эцэг эхийн шийдвэр байдаг. Өөрийн хүүхдээ чөлөөт цагаа үр дүнтэй, янз бүрээр өнгөрөөхөд нь дэмжээрэй. Дараах линкээс санаа аваарай: www.inkluzivniskola.cz/zdroje-inspirace/nabidka-volnocasovych-aktivit.

Би байгальдах аялал курсд шаардлагатай хэрэгсэл авахын тулд мөнгө хүртэл зээлж, сургууль уруу олон удаа очсон ч эцсийн эцэст энэ? Би үргэлж ажиллах хэрэгтэй болохоор ийм аялал зугаалага хүүдээ зориулж хийж чадахгүй.

бүх найзууд маань
надтай найзлахаа
болино...

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

31 дүрээр зүйл: Хүүхэд тоглох амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх эрх

Хүүхэд тоглох амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх , уран бүтээл, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцох, соёлын болон уран бүтээлийг өөрийн авъяас дээр тулгуурлан хөгжүүлэх эрхтэй.

Чөлөөт цагт зориулсан дугуйлан секц нь үе тэнгийнхэн хамт олондоо гишүүнчилэн ороход туслах, чех хэлний чадварыг хөгжүүлэх үр дүнтэйгээр чөлөөт цагаа өнгөрүүлж сурахад нь тусладаг.

Хүүхдүүдийн эцэг эхтэй холбоо тогтоож ярилцахыг хялбарчилсан аргачлалыг ашиглана уу (www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/informace-pro-rodice-jazykove-verze). Эсвэл та өөрөө ангийн бусад сурагчид дэмжлэгтэйгээр харилцааны пиктограм карт бүтээж болно- олон жишээ байдаг (www.inkluzivniskola.cz/content/komunikacni-karticky).

дараах линкүүдээс www.inkluzivniskola.cz/organizace-integrace-cizincu/volnocasove-aktivity Гадаад иргэдийн хүүхдүүд хэдийгээр тэд Чех хэлний хангалтгүй түвшинтэй ч байсан ч чөлөөт цагт зориулсан дугуйлан секцэнд яагаад хамрагдах хэрэгтэй дурдсан шалтгаан, санааг олж уншина уу. Эдгээр нь танд хүүхдүүд яагаад үдээс хойшхи сонгон суралцах дугуйланд явах хэрэгтэйг тайлбарлах аргумент болох ба цаашлаад эцэг эх , сонгон суралцах дугуйлангийн зохион байгуулагчтай харилцах үед хэрэг болно.

Түүнд ямар нэг юм хэрэгтэй болвол би түүнийг ойлгохгүй? Ямар нэг юм тохиолдсон үед яаж ойлголцох юм вэ? Түүнд даатгал байгаа ч юм уу???

10. Бүх зүйл цэцэрлэгт байхаас эхэлнэ

Спиро 5 настайдаа цэцэрлэгт орсон. Тэрээр аав ээжтэйгээ амьдардаг ч аав нь ихэвчлэн Грек улсад байдаг учраас зөвхөн ээжтэйгээ хоёулахнаа амьдардаг ба гэртээ грек хэлээр ярилцдаг. Цэцэрлэгт ороходоо Чех хэлийг бараг мэдэхгүй байсан. Спиро цэцэрлэгийн хүүхдүүдтэй дасах тэдний дунд уусан орж чадахгүй байлаа. Спиро бусад хүүхэдтэй хамт тоглож харилцахгүй ганцаараа ч тоглодоггүй ихэнхдээ тоглоомын өрөөгөөр ганцаараа зугаалж алхана. Цаашид байдал нэг их дээрдсэнгүй. Хүүг долоон нас хүртэл нь цэцэрлэгт үлдээж өөрөөс нь дүү хүүхдүүдтэй нэг ангид байсан учраас тэдний дунд хамгийн өндөр том нь байлаа. Спиро цэцэрлэгт 2 жил өнгөрөөсөн ч түүний чех хэлний түвшин маш муу байлаа. Цэцэрлэг дээр долоо хоногт хоёр удаа явагддаг чех хэлний курсэд хүүгээ хамруулахыг ээжид нь зөвлөсөн ч ээж нь зөвшөөрөөгүй бөгөөд Спирогийн хэлний чадвар асуудалгүй бүх юм болж байна гэж үзнэ. Чех хэлний курс эсвэл боловсрол-сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг төвд очиж зөвөлгөө авах саналыг хүүгийнх нь чадварыг дорд үзсэнд тооцож байлаа. Спиро бага ангид орохын хэдэн сарын өмнө (цэцэрлэгт хоёр жил явснаас хойш) чех хэлээр богино өгүүлбэр хэлж чадахгүй байлаа.

Цэцэрлэг нь бага болон дунд сургуультай ижилхэн чухал боловсрол юм. (цэцэрлэгт төдийгүй) Багш нарын хүмүүжүүлийн арга барил нь хүүхдүүдийн өөрийнхөө тухай бодол, өөртэй итгэх итгэл, сургууль хамт олон цаашлаад нийгэм (Чех) орчинд өөрийг нь хүлээн зөвшөөрч, гишүүлчлэн авах сэтгэгдэл тэмүүлэлийг бий болоход чухал нөлөөтэй. Тиймээс бид багш нарын хүүхдүүдтэй харьцаж байгаа арга зүй нь дээрх үйл явцад сөргөөр нөлөөлж байгаа жишээг дурьдмаар байна:

„Хүүхдүүдээ, нүүр гараа угаагаарай! Харин Вьетнамчууд үлдээрэй!“ гэж нэг багш ангийнхандаа хэлэх жишээтэй, Мөн ярилцсан. ангийн нэг сурагчаас „Чиний нэр хэн бэ?“ гэж асуухад тэр хүүхэд „Намайг Вьетнамчууд“ гэж хариулсан.

„Би түүнд Венца гэж нэр өгсөн. Тэрийг Венца гэж дуудахад сонсож мэддэг“ Цэцэрлэгийн багш хүүг цэцэрлэгт орсон хагас жилээс хойш өөрт хялбар байхаар өөрийнх нь нэрнээс өөрөөр дуудаж эхлэсэн. Гэвч хүүгийн жинхэнэ нэр тийм хэцүү байгаагүй.

ЕХ-ны иргэний хүүхдүүд цэцэрлэгт ороход Чех улсын иргэнтэй ижил эрхтэй ба ЕХ-оос бусад нарыг иргэдийн хүүхдүүд цэцэрлэгт орсноос хойш нэг хонгийн дараа оршин суух зөвшөөрөлийн бичиг баримтаа үзүүлнэ.²⁵

Сургуулийн өмнөх боловсрол олгох газар чех хэл мэдэхгүй хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэй хамт тоглож буй эсхүл ганцаараа тусдаа тоглодог эсэх талаар багш нараас лавлан асуугаарай. Туршлагаас харахад ирээдүйд сургууль дээр үе тэнгийнхэнтэйгээ ямар харилцаатай байх суурь үндэс нь цэцэрлэг дээр тавигддаг.

Чех хэлний курсэд хамрагдах болон зөвөлгөө өгөх төвд хандах нь ичих зүйл огтхон ч биш. Жишээлбэл боловсрол-сэтгэл зүйн төвд хандах нь Чех эцэг эхчүүдийн хувьд энгийн зүйл билээ. Сэтгэл зүйч цэцэрлэгтэй байнга хамтран ажилладаг. Зөвөлгөө өгөх төвийн жагсаалтыг дараах линкээс харна уу www.msmt.cz/vzdelavani/socialni-programy/pedagogicko-psychologicke-poradny. Боловсрол-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүд нь одоогийн байдлаар эх хэл нь Чех хэл биш хүүхдүүдийн сургуульд ороход бэлэн эсэх тухай материалыг бэлтгэж гаргаагүй байгаа. Тухайн төвд хандахдаа Чех хэлний орчуулагч болон тухайн төв нь чехээр ярьдаггүй хүүхдүүдтэй харилцах туршлагатай эсэхийг урьдчилан мэдвэл сайн.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

8 дүрээр зүйл: Хувийн онцлог байдлаа хадгалах эрх

Хүүхэд бүр хувийн онцлог байдлаа хадгалах эрхтэй үүнд овог нэр, гэр бүлийн холбоогоо хадгалах мөн иргэний харъяалал ч багтана.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдүүд бага сургуулийн боловсролын хөтөлбөртэй ижил дэмжлэг тусламж авах эрхтэй (тусгай туслах багшийн үйлчилгээ, зөвлөгөө авах, хэлний курс, хувийн сургалтын план г.м). Чех хэлтэй хүүхдүүдтэй хамт нэг ангид суралцаж байгаа гадаад хүүхэд бусдаасаа автоматаар чех хэлийг сурна гэж ойлгож болохгүй. Нийгэмших явц нь удаашралтай хүүхдүүдэд илүү дэмжлэг үзүүлж, янз бүрийн үйл ажиллагаанд хамруулж хамт олонд уусах, хэл сурах явцыг нь дэмжих хэрэгтэй.

Бага насны хүүхдүүд өөрт нь болон бусад хүүхдүүдэд сануулж загнаж байгааг анзаардаг ч багшийнхаа хийж байгаа үйлдэлийг хурдан дуурайж сурдаг. Тиймээс өөрийн үйлдэлдээ онцгой анхаарал хандуулаж зөв сурган хүмүүжүүлэх, эелдэг зан үйл аргачлалыг хэвшилээ болгоорой. Бага насны хүүхдүүд ч хүндлэл эдлэх эрхтэйг битгий мартаарай.

Хүүхдийг гарал үүсэл, хувийн онцлог байдлаас нь үүдэн нэрлэх нь зохимжгүй юм. Хүүхдэд хэдий чинээ өөрийнх нь ялгаа онцлогийг нь сануулсан хандлага гаргана төдий чинээ түүний хамт олны дунд орох нь удааширч сөргөөр нөлөөлнө.

Нэрийг эцэг эх нь өгсөн тэр нь түүний хувийн онцлог байдлын чухал хэсэг. Тиймээс өөр нэр хочоор дуудах нь тохиромжтой эсэхийг бодож үзээрэй. Мэргэжилтүүнд зөвлөхдөө хүүхдийн жинхэнэ нэрийг хэрэглэх нь тохиромжтой гэдэг ба жишээ нь нэрнийх нь богино (эцэг эхтэй нь тохиролцсоны үндсэн дээр) хэлбэрээр дуудаж болно.

Цэцэрлэгт чех хэлний курс явуулах нь цэцэрлэгийн үүрэг биш ч сонирхолын дагуу курс зохион байгуулж, санхүүжилт хүсэж болно. Санааг дараах линкээс: эсвэл www.inkluzivniskola.cz/organizace-aneb-cizinci-ve-skole/jazykovy-rozvoj-v-kurzu.

Дараагийн дэмжлэг санаа авах арга зүйн материалыг „Цэцэрлэг дэх өөр эх хэлтэй хүүхдүүд“ хэсгээс харна уу www.inkluzivniskola.cz/zdroje-inspirace/metodika-deti-s-odlisnym-materskym-jazykem-v-materskych-skolach. Материалаас өөр төрөлх хэлтэй хүүхдийг хүлээн авахад яаж бэлдэх, тэдний эцэг эхтэй яаж харилцах хүүхдүүдийн дунд оруулах арга зааварчилгаа, хэлний түвшинг сайжруулахад туслах арга мөн хууль дүрэмийн талаар мэдээлэл зэрэг практик мэдээллийг уншаарай.

11. Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй тохиолдолд (сургуулийн зөвөлгөө өгөх төвийн тухай дэлгэрэнгүй)

Лин хичээл дээр ямар ч амжилтгүй сурсан ба Боловсрол- сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төвөөс оюуны хомсдолтой гэж оношилсон байна. Мэдээгээр ганц шийдвэрлэх арга нь сургууль гэж тодорхойлсон байлаа. Эцэг эх нь зөвхөн Вьетнамаар ярьдаг байсан учраас төвийн сэтгэл зүйчид онолшилгоо мэдээг шууд сургууль уруу явуулахаар шийдвэрлэлээ. Үүнээс болж эцэг эх нь оношилгооны талаар ямар ч мэдээлэлгүй ялангуяа өөрсдийн эрх, дараагийн боломжийн тухай мэдээгүй хоцорлоо. Эцэг эх нь сургуулийг нь солихийг хүссэнгүй хэн ч тэдэнд ямар боломжтойг нь хэлсэнгүй.

Зургаан настай Борис хүүхдийн тархины цус харвалт болсон учраас бусдын тусламжгүйгээр бараг хөдөлж чаддаггүй ба ганцаараа явж чадахгүй байлаа. Түүний сургуульд орох цаг болсон хэдий ч өөр санаа зовох зүйл хангалттай ихтэй түүний ээж хүүтэйгээ сургуулийн бүртгэл юунд хэрэгтэй ч ойлгоогүйгээр барахгүй хүүхдийн эмчид очилгүй өнгөөрлөө. Хүүгийн ойлгох чадвар хурдан, хэдийгээр сурахыг хүсэж байсан ч сургуульд явахын оронд гэртээ үлдэв.

Хараагүй Хануг сургуулийн захирал сургуульд авахаас татгалзан чех хэл сурсаныхаа дараа сургуульд бүртгүүлэхийг хэллээ. Охин МЕТА-д чех хэлний курсд хамрагдаж мөн эцэг эх нь гэртээ охиндоо чех хэл зааж байлаа.

Сургуулийн зөвөлгөө өгөх төвүүд нь танд болон тусламж үзүүлэх хамгийн сайн боломжийг таны хүүхдэд хайж олох ба тухайн төвд хандах нь ичих зүйл биш бөгөөд олон чех гэр бүлүүд ханддаг. Боловсрол- сэтгэл зүйн зөвөлгөө төвд хандахаас айх хэрэггүй ба хэлний эсвэл эрүүл мэндийн бэрхшээлээс шалтгаалах үед дэмжлэг арга хэмжээг хэрхэн бүрдүүлэх талаар сургуульд зөвлөмж (туслах багш, сургалтын хувийн план) хүргэх юм.

Зөвөлгөө өгөх төвийн үйлчилгээ үнэ төлбөргүй. Төв нь орчуулагчын үйлчилгээг үзүүлэхгүй ба зөвөлгөөнд хэлмэртэй очвол байдлыг хөнгөвчлөх болно.


СУРГУУЛИЙН ЗӨВӨЛГӨӨ ӨГӨХ ТӨВ ГАДААД ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААН ДЭЭР ТУРШЛАГАГҮЙН УЛМААС ҮЛ ОЙЛГОЛЦЛОЛООС БОЛЖ СТАНДАРТЫН БУС БАЙДАЛ ҮҮСЧ ХОЛБОГДОХ ЖУРАМ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ АЛХАМ ХИЙХ ЁСТОЙ БОЛДОГ ҮҮНИЙ ЦААД ЗОРИЛГО НЬ ӨӨР МЭРГЭЖИЛТЭН ЦААШЛААД ОРЧУУЛАГЧ ХЭЛМЭРЧИЙГ УРИХ ЯВДАЛ ЮМ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд заавал хамрагдах ёстой сургуулийн ирцийг хөнгөвчлөх арга боломж байх ёстой.

Зөвөлгөө өгөх төв нь сургуульд бэлэн байдал, тодорхой тохиолдолд сурах байдлын дутагдалыг илэрүүлэх, дэмжлэг арга зүйн заарчилгааг өгдөг. Сургалтын саад бэрхшээл нь хэл мэдэхгүй байдал гэдгийг тогтоож үүнийг дэмжлэг туслалцаа зөвлөж болно.



Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч шинжилгээний хариу дүнг ойлгомжтой аргаар хамгийн түрүүн мэдэх эрхтэй! Төвөөс хүүхдийн тухай хөтөлж буй карттай та уншиж танилцах эрхтэй. Шинжилгээний хариу мэдээг ойлгомжтой тайлбартайгаар танд буюу эцэг эхэд харин та дараа нь сургуульд дамжуулж өгөх ба сургууль сургалт хичээлд ашиглахын тулд зөвлөмжтэй танилцах хэрэгтэй. Хэн нэгний хувийн мэдээлэл биш.



Соёлын ялгаа онцлог нь хамгийн чухал үүргийг гүйцэтгэж болно - зарим нэг орон үндэстний хувьд хүлээн авахад хэцүү тэдний хүүхдүүд нь ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй байж болох үүнээс үүдэн зөвөлгөө өгөх төвийн үйлчилгээг авах зэрэг нь тэдний хувьд тааламжтай бус юм. Тухайн үед сэтгэл зүйчидхандах нь гаж буруу, хачин жигтэй, гайхмаар сэтгэлээр үзэж үл болно гэдгийг сайтар тайлбарлаж урамшуулах.

Бүх зөвөлгөө өгөх төв, газрууд хэлний бэрхшээлтэй ажиллах туршлагагүй байдаг. Тэдний оношилгооны арга барил чех хэлээр байдаг. Харин чех хэлээр харилцаагүй тохиолдолд шилжилгээний хариу дүгнэлтэнд магадгүй зарим нэг саад хүндрэлийг таниж мэдэхгүй өнгөрөх тохиолдол байж болно.

Хүүхэд бүр сургууль дээр дэмжэлг авах эрхтэй юм. Чех улсын боловсролын тогтолцоонд бүх сурагчдыг нэгэн тэгш оролцуулах боловсролын журмыг хэрэгжүүлэхээр болсон. Тийм болохоор бүлгийн дасан захицолоос хувийн интеграцийг илүүд үзвэл зохилтой. Нэг үгээр хэлэхэд хүүхдүүд энгийн сургуульд үлдэж шаардлагатай боломжит бүх төрлийн дэмжлэгийг авах хэрэгтэй юм.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕЦИД ЮУ ГЭЖ ЗААСАН:

5 дугаар зүйл: Эцэг эхийн хариуцлага

Эцэг эх хүүхдийн өмнөөс хуулийн дагуу хариуцлага хүлээх, асран хамгаалах, боловсрол, хөгжилд хариуцлага хүлээх үүргийг бусад хүмүүс хүндэтгэн нийцүүлэнэ.

23 дугаар зүйл: Тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхдийн эрх

Тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхдүүд нь бусдын ижил эрхтэй. Ийм хүүхэд онцгой халамж хүртэх эрхийг эдэлж тэдний нэр төрийг хүндэтгэн өөртөө тулгуурлах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжтой орчинд бүрэн бүтэн, зохистой амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ²⁶:

Боловсрол- сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төв (Зөвөлгөө өгөх төв)

- хүүхэд сурагчидийн хичээл сургалт хүмүүжилтэй хобоотой асуудлыг шийдвэрлэхэд тусладаг.
- зөвөлгөө өгөх үйлчилгээг эцэг эх, сургуульд хүргэдэг
- хүүхдийн хувийн болон нийгэм дэх хөгжлийн талаарх асуулт, мэргэжлийн боловсролын сонголтын бусад асуултанд туслахад чиглэнэ.

Сургалт арга зүйн тусгай зөвөлгөө өгөх төв (Төв)

- хөгжлийн бэрхшээлтэй болон тахир дутуу сурагчидад зөвөлгөө үйлчилгээг үзүүлдэг
- сургалт арга зүйн болон сэтгэл зүйн тусгай мэргэжлийн хэрэгцээт тусламжийг хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид сургалтын болон нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг гэр бүл, сургууль, сургуулийн өмнөх боловсролын төвийн зөвөлгөө өгөх төв тэдний мэргэжлүүндтэй хамтран хүргэх юм.

16 дугаар зүйл: Сургалтын тусгай хэрэгцээт сурагчийн боловсрол

6 дугаар бүлэг: Хөгжлийн бэрхшээлтэй болон тахир дутуу сурагчийг сургалтболовсролын төвд элсүүлэн авах эсвэл сургалт боловсролын төвийг дуусгах үед тэдний хэрэгцээнд тохирсон нөхцөлийг бүрдүүлэнэ. Тэдний сургалтын дүнд хөгжлийн бэрхшээлийг харгалзан дүгнэнэ. Дунд болон мэргэжилд бэлтгэх сургуулийн захирал онцгой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчийн сургалтын хугацааг 2 хүртлэх жилээр сунгаж болно.

7 дугаар бүлэг: Хөгжлийн бэрхшээлтэй болон тахир дутуу сурагчид сурах бичиг сургалтын туслах хэрэгцээт тусгай хэрэгсэлийг үнэ төлбөргүй хэрэглэх эрхтэй. Сонгол хараагүйчид сургалтын хэрэгцээ болох харилцааны хэрэгслийн систем, хараагүй сурагчид брайлын үсэг, ярих системийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ойлголцох байдлыг орлуулах арга зэргийг боловсрол эзэмшихид нь бүрдүүлсэн байх ёстой.

26) Боловсролын тухай хуулийн 116 -р бүлэг сургуулийн зөвөлгөө өгөх төвийн тухай / 72/2005 тоот тогтоол сургууль болон сургуулийн зөвөлгөө өгөх газарт зөвөлгөө үйлчилгээг хүргэх тухай / 73/2005 тогтоол онцгой авъяастай хүүхэд сурагч болон сургалтын тусгай хэрэгцээтэй сурагч оюутнуудын боловсролын тухай.

Холбоо барих

META, o.p.s.

залуу гадаад иргэдэд зориулсан төрийн бус байгууллага

www.meta-ops.cz

www.inkluzivniskola.cz

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ (БШУЯ)-НЫ БОЛОВСРОЛЫН ГАЗАР 21

www.msmt.cz/ministerstvo/skupina-pro-vzdelavani

ЧУ-ЫН БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

www.csicr.cz

СУРГУУЛИЙН ОМБУДСМЕН

tel.: 234 812 211, e-mail: ombudsman@msmt.cz

ОЛОН НИЙТИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАГЧ (ОМБУДСМЕН)

tel.: 542 542 888, e-mail: podatelna@ochrance.cz

АЙМГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОВСРОЛЫН ХЭЛТЭС

www.statnisprava.cz/rstsp/ciselniky.nsf/i/d0049

ЧУ ДАХ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ - СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВҮҮД

[www.msmt.cz/vzdelavani/socialni-programy/
pedagogicko-psychologicke-poradny](http://www.msmt.cz/vzdelavani/socialni-programy/pedagogicko-psychologicke-poradny)

ЧЕХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ЗӨВЛӨЛ НЬ ХҮҮХЭД

<http://crdm.cz/>

ЧУ ДАХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ТӨВҮҮД

http://spddm.org/Clenove_SP_DDM_seznam.html

ГАДААД ИРГЭДЭД ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

- ЧУ дах гадаад иргэдтэй ажилдаг ТТБ-ын консорциум
www.konsorcium-nno.cz
- Гадаад иргэдийн интеграцийг дэмжих төв
www.integracnicentra.cz
- Гадаад иргэдийн интеграцийн төв
www.cicpraha.org
- Соёл хоорондын ажлыг дэмжих ассоциаци
<http://interkulturniprace.cz/>
potrebujii-interkulturniho-pracovnika
- Дотоод Хэргийн яамны гадаад иргэдэд зориулсан мэдээллийн портал
www.cizinci.cz

ХЭЛМЭРЧ, ОРЧУУЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- Комунитны хэлмэрч
www.meta-ops.cz/kontakty-na-komunitni-tlumocniky
- Харита байгууллагын үтасаар хэлмэрчлэх үйлчилгээ
[www.charita.cz/jak-pomahame/pomoc-cizincum-v-cr/
infolinka/](http://www.charita.cz/jak-pomahame/pomoc-cizincum-v-cr/infolinka/)

АНГИ ХАМТ ОЛОН, ХИЧЭЭЛ СУРГАЛТАД ЗОРИУЛСАН МАТЕРИАЛ

- Хүнд нөхцөлд туслах байгууллага „Тэд Чадна!“
www.majinato.cz
- Чех хүүхэд
www.czechkid.cz
- Европын комис – Хүний эрхийн тухай боловсролын гарын авлага
www.coe.int/en/web/compass
- META материалын хураангуй
www.meta-ops.cz/metodicke-a-vyukove-materialy

БОЛОВСРОЛЫН ПОРТАЛУУД

- www.ceskaskola.cz
- www.eduin.cz
- www.inkluzce.cz

ХҮҮХДИЙН ЭРХ

- БШУЯ – ны хүүхдийн эрхийн мэдээллийн портал
www.pravonadetstvi.cz

САЙН ДУРЫН АЖИЛТАН

- Сайн дурын ажилчдын програм 5P
www.hest.cz/cs-CZ/co-delame/program-pet-p
- Дүрвэгсдэд туслах сайн дурын ажилчдын мэдээллийн сан
www.idobrovolnik.cz
- LATA – гэр бүл залуучуудад зориулсан програмууд
www.lata.cz

ХУУЛЬ ТОГТООМЖУУД

- Бага, дунд, бүрэн дунд мэргэжлийн болон бусад төрлийн боловсролын байдлыг зохицуулах 561/2004 тоот Боловсролын тухай хууль
- Үндсэн боловсрол болон заавал хамрагдах ёстой боловсролд хамрагдах байдлын зарим шаардлагат зүйлийг зохицуулах 48/2005 тоот тогтоол
- Сургалт боловсрол олгох төвүүдийн зөвлөгөө өгөх газар болон сургуулийн орчинд зөвлөгөө өгөх үйлчилгээг зохицуулах 116/2011, 72/2005 тоот тогтоол,
- Боловсролын тусгай хэрэгцээт хүүхэд, сурагч, оюутан болон онцгой авъяастай хүүхэд, сурагч, оюутаны боловсрол эзэмших байдлыг зохицуулах 73/2005, 147/2011 тоот тогтоолууд
- Захиргааны журамыг зохицуулах 500/2004 тоот хууль
- Ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх 198/2009 тоот хууль. НЭМЭЛТ!

